



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/209

Улаанбаатар хот

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын
хорооны бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан, салбар хороодын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Оюунбилэг/-д даалгасугай.

3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны ажлыг дэмжин ажиллаж, хорооны үйл ажиллагааны зардал, гишүүдэд үнэмлэх олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/267, 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/275 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141220150

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
... дугаар сарын ... өдрийн
... дугаар тушаалын хавсралт



Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны бүрэлдэхүүн

Хяналтын хорооны дарга: Д.Оюунбилэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш

Хяналтын хорооны нарийн бичгийн дарга Ц.Тунгалагтамир, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтсийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эмнэлгийн мэргэжилтнийг ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх зөвлөлийн дарга: Б.Пүрэвжав, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн аюулгүй байдал, тандалт, судалгааны газрын дарга

Эмнэлгийн мэргэжилтнийг ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх зөвлөлийн гишүүд: М.Цэрэнбат, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Бионагаахын сургуулийн Эмгэг судлал, шүүх эмнэлгийн тэнхимийн дэд профессор

Б.Саранцэцэг, Шинэ анагаах ухаан их сургуулийн Инновацийн төвийн захирал

М.Ундрэм, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Анагаах ухааны сургууль, Өрхийн анагаах ухааны тэнхимийн ахлах багш

Ш.Цэрмаа, Натул эмнэлгийн сургалт, сувилахуйн албаны дарга

Ч.Батнайрамдал, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн захирал

Орлогч дарга-Иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх зөвлөлийн дарга:

Иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүд:

Ш.Оюунчимэг, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн Захиргаа, удирдлагын асуудал эрхэлсэн захирал

Б.Болорхорлоо, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтсийн Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Ш.Алтанцэцэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын албаны дарга

М.Болдбаатар, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн Хүүхдийн гэмтэл, согогийн тасгийн эрхлэгч

Д.Цэцэгээ, “Хүрээ амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал

З.Хишигсүрэн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн эрхлэгч

Ч.Одгэрэл, Геронтологийн үндэсний төвийн Эмнэлгийн тусламжийн албаны дарга